

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 08 сарын 21 өдөр

№ R-2025-36

Улаанбаатар хот

Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр батлах тухай

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.11 болон 36.12 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгч болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А-262/262 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журмын 1 дүгээр зүйлийн 1.2.6 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.26 дахь хэсэгт тус тус заасны дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:


- Банкны хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн R-2025-12 тоот тогтоолоор батлагдсан Банкны хувьцаа эргүүлэн худалдан авах өмнөх хөтөлбөр дуусгавар болсноос хойш үргэлжлүүлэн, 8 сарын хугацаатай хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг батлахыг ТУЗ-д санал болгосныг; мөн
- ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын саналыг хэлэлцээд хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Монголбанкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр ("Хөтөлбөр")-ийг Банк өөрийн гаргасан энгийн хувьцааны 5,000,000 (таван сая) ширхэг хүртэлх хувьцааг эргүүлэн худалдан авах эрхтэйгээр, дараах нөхцөлөөр баталсугай:

1	Эргүүлэн худалдан авах хувьцааны тоо	5,000,000 ширхэг хүртэл
2	Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнэ	980 төгрөг хүртэл
3	Хөтөлбөрт зарцуулах нийт дүн	4,775,000,000 төгрөг хүртэл
4	Хөтөлбөр хэрэгжих хугацаа	8 сар

- Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа нь Монголбанкны зөвшөөрөл олгож, нийтэд зарласан өдөр эсхүл ТУЗ-ийн R-2025-12 тоот тогтоолоор батлагдсан хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр дуусгавар болсон өдрийн аль сүүлийн өдрөөс эхлэн 8 сарын хугацаанд үргэлжлэх ба нийт эргүүлэн худалдан авах хувьцааг бүхэлд нь худалдан авсан, эсхүл Хөтөлбөрт зарцуулах нийт дүнг бүрэн зарцуулснаар уг хугацаанаас өмнө дуусгавар болж болно.
- Хөтөлбөрийн дагуу эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасалсугай.



4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувьцаа эргүүлэн худалдан авах ажлыг гүйцэтгэх, зохицуулагч байгууллагаас зохих зөвшөөрөл авах, харилцах зэрэг энэ ажлыг зохион байгуулахтай холбоотой шаардлагатай, эсхүл зохистой гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгаж, холбогдох эрхийг олгосугай.
5. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ





МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,

Цахим хуудас: www.mongolbank.mn

2025.10.06 № A-1/471
танай _____-ны № _____-т

ХАС БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ЦЭВЭГЖАВ ТАНАА

Танай банкнаас 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 1/9400 дугаар албан бичгээр ирүүлсэн олон нийтэд санал болгож гаргасан хувьцааны тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч, халааслах хүсэлттэй танилцлаа.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалт, Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.12 дахь хэсгийг үндэслэн Хас банк нь хувьцаа эргүүлэн худалдан авч, халаасласны дараа Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа тул олон нийтэд санал болгож гаргасан 5,000,000.00 (таван сая) ширхэг хүртэл хувьцааг нэгж бүрийг нь 980.00 (есөн зуун ная) хүртэлх төгрөгөөр буюу нийт 4,900,000,000.00 (дөрвөн тэрбум есөн зуун сая) хүртэлх төгрөгөөр эргүүлэн худалдан авахад татгалзах зүйлгүй болно.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН

1525032021

ХАСБАНК ХК

Үнэт цаасны үнэ, ханшид нөлөөлж болох мэдээлэл

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/	
Тайлагнах хугацаа	2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: ХасБанк ХК УБГД: 000239852 РД: 2578697 Үнэт цаасны код: MN00XAC05687 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72 Утас: 75771888 И-мэйл: info@xacbank.mn Вэбсайт: www.xacbank.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Н.Цэлмэгхишиг, ТУЗ-ийн ажлын албаны хуульч Хянасан: Н.Мөнхцэлмэг, Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
1. Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр хэрэгжүүлэх зөвшөөрөл олгосон тухай	
ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-36 дугаар тогтоолоор хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг 8 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд Монголбанкнаас 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр зохих зөвшөөрлийг олгосон болно.	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	

Овог, нэр: Н.Цэлмэгхишиг

Албан тушаал: ТУЗ-ийн ажлын албаны хуульч

Гарын үсэг:



Хянасан: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

A black ink handwritten signature.

Огноо: 2025 он 10 сар 06 өдөр